


# НИФАЙН ХҮМҮҮС

## ХРИСТИЙН ШАВЬ НАР БАЙСАН

**А**милсан Аврагч зөв шударга нифайчууд дээр зочлохдоо тэднийг Өөрийн гар дээрх болон хөлөн дэх “хадаасны ормуудыг тэмтэрч үзэхэд” урьсан. Есүс тэдэнд Өөрийгөө “бүх дэлхийн Бурхан, мөн дэлхийнхний нүглүүдийн төлөө егүүтгэгдсэнийг” (3 Нифай 11:14) мэдүүлэх хүсэлтэй байсан. Олон хүн Есүс рүү “нэг нэгээрээ” очив. Есүс Христтэй нэг нэгээрээ уулзсанахаа дараа нифайчууд Түүнийг бошиглогдсон Аврагч гэдгийг мэдсэн (3 Нифай 11:15). Хэдийгээр Есүс Христ өнөөдөр бидний өмнө биечлэн үзэгддэггүй ч бид Түүнтэй хувийн гүн гүнзгий харилцаа тогтоож чадна.

Нифайчуудын нэгэн адил би Христэд ирж, Түүний тухай суралцаж, Түүний талаарх гэрчлэлээ хүчирхэгжүүлж чадна.



## БИ Ч ГЭСЭН ШАВЬ НЬ



*Дээрх хүмүүсийн туршлагын талаарх видеог эндээс үзээрэй.*  
(Бүх хэл дээр боломжгүй байж болно.)